



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/З/04

Чингис хот

“Төрийн байгууллагын тохижилт-100” уралдааны  
шагналд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтууд, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 100 жил, Хэнтий аймаг байгуулагдсаны 98 жилийн ойг тохиолдуулан төрийн байгууллагууд, төрийн өмчит үйлдвэрийн газар, хувьцаат компаниудын дунд зохион байгуулсан “Төрийн байгууллагын тохижилт-100” уралдааны шагналд зориулж 1,750,000 (нэг сая долоон зуун тавин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шагнал урамшуулалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011341

08 Аймгийн Засаг даргын 2021 оны  
дугаар сарын 08 өдрийн А/1904  
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

д/д	Зориулалт	Тоо хэмжээ * Нэгж үнэ	Мөнгөн дүн
1	Уралдааны 1 дүгээр байр	1* 1,000,000	1,000,000
2	Уралдааны 2 дугаар байр	1* 750,000	750,000
<b>Нийт</b>			<b>1750000</b>